



**ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 03 сарын 01 -ны өдөр

Дугаар A/20

Эрдэнэт

Коронавируст халдвар /Ковид-19/-ын дархлаажуулалтын үед дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийг тандан судлах мэргэжлийн баг томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6а, 29.2 дахь хэсэг, "Дархлаажуулалтын тухай" хуулийн 5.2 заалт, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/278 дугаар тушаалын нэг, хоёрдугаар хавсралт, 2018 оны А/257 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт, 2019 оны А/611 дүгээр тушаал, 2012 оны 217 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийг тандан, судлах мэргэжлийн багийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Уг дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн тохиолдол бүрийг батлагдсан судалгааны хуудсаар тандалт хийж, Эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг мэргэжлийн багийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.
3. Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн судалгааны хуудсыг аймгийн МХГ-ын эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагчид хүргүүлэн, сэжигтэй тохиолдлыг тухай бүрт нь магадлан тогтоолгохыг мэргэжлийн багийн ахлагчид даалгасугай.
4. Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийг тухай бүр бүртгэн, шуурхай мэдээлж, хариу арга хэмжээ авч ажиллахыг нийт Эрүүл мэндийн байгууллагуудын дарга нарт үүрэг болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн төв /А.Баярхүү/-д үүрэг болгосугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Д.СҮХЭЭ



Эрүүл мэндийн газрын даргын  
2021 оны 02 дугаар сарын  
01-ний өдрийн 010 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт



Коронавируст халдвар /Ковид-19/-ын дархлаажуулалтын үед дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийг тандан судлах мэргэжлийн багийн бүрэлдэхүүн

**Багийн ахлагч:**

- ЭМГ-ын Халдварт өвчний тандалт сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн

**Гишүүд:**

- Эрүүл мэндийн газрын даргын зөвлөх
- ЭМГ-ын Яаралтай тусламж, гамшгийн үеийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- ЭМГ-ын Анхан шатны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
- БОЭТ-ийн Мэдрэлийн их эмч
- БОЭТ-ийн Клиник лабораторийн эрхлэгч их эмч
- БОЭТ-ийн Нян судлалын лабораторийн их эмч
- БОЭТ-ийн Мэс заслын тасгийн эрхлэгч
- БОЭТ-ийн Харшлын их эмч

**Нарийн бичиг:** ЭМГ-ын дархлаажуулалт хариуцсан бага эмч

Эрүүл мэндийн газрын даргын  
2021 оны 03 дугаар сарын  
01.-ний өдрийн 4/0 дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт

ДАРХЛААЖУУЛАЛТЫН ДАРААХ УРВАЛ, ХҮНДРЭЛИЙГ ТАНДАН СУДЛАХ МЭРГЭЖЛИЙН  
БАГИЙН АЖИЛ ҮҮРГИЙН ЧИГЛЭЛ:

Багийн ахлагч нь: Сум, өрхийн эрүүл мэндийн төвөөс мэдээлсэн дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийг бүртгэн авч, Эрүүл мэндийн сайдын 2012 оны 217 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан судалгааны хуудсаар тандалт хийж, ХӨСҮТ-д болон аймгийн МХГ-т 24 цагийн дагуу мэдээлнэ. Судалгааг авч дууссаны дараа мэргэжлийн багийг хуралдуулна.

Мэргэжлийн баг нь:

1. Эмнэлгийн тусламж үйлчилгээ, судалгаа, хариу арга хэмжээнд дүгнэлт хийнэ.
2. Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн сэжигтэй иргэнд үзүүлж буй эмнэлгийн тусламж үйлчилгээг шаардлагатай тохиолдолд дараагийн шатны эмнэлэгт шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.
3. Сэжигтэй тохиолдлыг аймгийн эм, биобэлдмэл, эмчилгээний чанарын хяналтын улсын алба, эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагчид мэдээлж, магадлан тогтоолгоно.
4. Вакцин, зүү, тариур өтгөнөөс авсан шинжлэгдэхүүнд лабораторийн шинжилгээ хийлгэж хариуг албан ёсоор хүргүүлнэ.
5. Цаг хугацаа, газар зүйн адил байрлалд нэг төрлийн вакцин тариулсан, ижил шинж тэмдэгтэй дархлаажуулалтын дараах хүндрэлийн сэжигтэй тохиолдол байгаа эсэхийг илрүүлэх, идэвхтэй тандалт хийх, эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа өвчтөн, өвчний түүх, үзлэгийн журнал, дуудлагын хуудас, хүлээн авахын бүртгэл зэрэгт тандалт хийнэ.